



ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 03 сарын 09 өдөр

Дугаар 4/198

Улаанбаатар хот

Хөдөлмөрийн биржийн эрхийг цуцлах тухай

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.9.5, 9 дүгээр зүйлийн 9.4 дэх заалт, Хөдөлмөрийн хувийн биржийг бүртгэж, санхүүжилт /тарифаар тооцож/ олгох журмын 2 дугаар зүйлийн 2.4.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Карьерийн эхлэл "ХХК-ийн дэргэдэх хөдөлмөрийн бирж нь 2018 оны 01 дүгээр сарын тайлан, "Монголын цахим институтын дэргэдэх" Хөдөлмөрийн бирж нь 2018 оны 2 дугаар сарын тайланг бодит бус, худал мэдээлэл оруулан түүнд үндэслэн санхүүжилт хүссэн байх тул эдгээр биржийн эрхийг цуцалж бүртгэлээс хассугай.
2. Цаашид хөдөлмөрийн биржийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, зөрчил гаргуулахгүй байхад анхаарч мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих газар /Ч.Саналбаяр/-т даалгасугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөрийн асуудал хариуцсан Дэд дарга /Б.Шижиржаргал/-д даалгасугай.

ДАРГА



Б.НЯМДАВАА